



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Чанарын гарын авлага, менежментийн
тогтолцооны журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоол, MNS/ISO/IEC 17025:2018 стандарт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/23 дугаар тушаал, Эм, эмнэлгийн хэрэгсэл, хяналт зохицуулалтын газрын даргын 2023 оны А/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм, Эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм шинжлэх лабораторийн MNS ISO/IEC 17025:2018 дагуу “Чанарын гарын авлага”-ыг нэгдүгээр, “Менежментийн тогтолцооны журам”-ыг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.“Чанарын гарын авлага”, “Менежментийн тогтолцооны журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Эм шинжлэх лаборатори (Ш.Сонинхүү)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2022 оны 02 сарын 10-ны өдрийн “Чанарын гарын авлага, менежментийн тогтолцооны журам батлах тухай” А/16 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ЗЭНДМАА



1423 010014